



ДУНДГОВЬ АЙМАГ

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2024 ОНЫ БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
ТАЙЛАН**

АГУУЛГА

| | |
|--|-----|
| Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго | 3 |
| Хоёр. Хяналт шинжилгээ, үнэлгээний үндэслэл, арга зүй..... | 3 |
| Гурав.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн..... | 3-5 |
| Дөрөв. Дүгнэлт | 6-9 |
| Тав. Санал, зөвлөмж | 9 |

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2025 оны 02 сарын 06

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, хүрсэн түвшнийг тусгагдсан зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй харьцуулан үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн шийдвэр, бодлого төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, удаашралтай хэрэгжиж байгаа зорилт, арга хэмжээг эрчимжүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2.1, 6.2.2, 6.2.3-т заасан арга зүйгээр төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ ирүүлсэн тайлангаас гадна иргэдэд ил тод мэдээлсэн эх сурвалжийн мэдээлэл, газар дээр нь очиж танилцах, нотлох баримтад үндэслэх, статистик мэдээлэлтэй тулган үзэх, холбогдох хэлтэс, алба, нэгжээс нэмэлт тодруулга авах, мэдээлэлтэй тулган үзэх замаар зэргээр хэрэгжилтийг баталгаажуулж, бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон 11 зорилт, 40 арга хэмжээний биелэлт болон төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх 25 зорилт, 80 арга хэмжээний биелэлтийн дундаж үнэлгээгээр тооцсон болно.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийн зорилтын хүрээнд 11 зорилт, 40 арга хэмжээ төлөвлөснөөс 11 зорилтын дундаж 87 хувьтай, 40 арга хэмжээний дундаж 87,5 хувьтай, Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд 25 зорилт, 80 арга хэмжээ төлөвлөснөөс зорилтын дундаж 91,5 хувьтай, 80 арга хэмжээний дундаж 90,7 хувьтай байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянан үзэж, өөрийн үнэлгээг **88,9 хувиар** үнэлэв.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ, 2024 он

| № | Үндсэн чиглэл | Зорилт | Арга хэмжээ | Биелэлтийн хувь | | | | | | Дундаж үнэлгээ /%/ |
|-------------|--|-----------|-------------|-----------------|-------------------------|----------|--------------------------|----------|-----------|-----------------------|
| | | | | Үр дүнтэй | Тодорхой үр дүнд хүрсэн | | Эрчимжүүлэх шаардлагатай | | Үр дүнгүй | |
| | | | | 100 | 90-71 | 70-60 | 50 | 30 | 0-5 | |
| 1 | Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийн зорилтын хүрээнд | 11 | 40 | 33 | | 2 | 1 | | 4 | 87,2 |
| 2 | Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд | 25 | 80 | 63 | 4 | 3 | 5 | 1 | 4 | 90,7 |
| Нийт | | 36 | 120 | 96 | 4 | 5 | 6 | 1 | 8 | 88,9 |

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээг тус оны 6 сард хийж, зорилт, арга хэмжээний дундаж 82,6 хувьтай, хугацаа болоогүй 15 арга хэмжээ, 0 хувьтай 10 арга хэмжээ байгааг эрчимжүүлж ажиллах чиглэл өгч, зөвлөн тусалж ажилласнаар жилийн эцэст 6,3 хувиар өссөн байна.

Тус онд зөвлөмжийг хэрэгжүүлж, үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор “Төлөвлөлт ба тайлагналтад анхаарах асуудал” сэдвээр нийт хэлтэс, албадын албан хаагчдад сургалт зохион байгуулж, ганцаарчилсан зөвлөмжийг мөн хэлтэс бүрийн албан хаагчдад өгч ажилласнаар төлөвлөлт, тайлагналтын чанар эрс сайжирч байна.

2024 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД:

Дундговь аймгийн хүний хөгжлийн индекс Статистикийн үндэсний хорооны сүүлийн үеийн мэдээгээр 0.747 байгаа нь өмнөх оноос 0,034 индексээр өссөн үзүүлэлттэй байна.



Аймгийн хүн амын дундаж наслалт 2020 онд 74,61 улсад тэргүүлдэг байсан бөгөөд 2023 онд 74.87 болж улсад 3 дугаарт эрэмбэлэгдэж байна. Энэ нь улсын дунджаас 3,37 насаар илүү байна.



Аймгийн эрэгтэй хүний дундаж наслалт 2023 онд 71,27, эмэгтэй хүний дундаж наслалт 80,03 болж, дундаж наслалтын зөрүү 8,76 байгаа нь өнгөрсөн оноос 0,18 - аар ойртсон байна.

| Статистик үзүүлэлт | Аймаг | Аймгийн код | 2020 | 2021 | 2022 | 2023 |
|--------------------|-----------|-------------|-------|-------|-------|-------|
| Эрэгтэй | Улсын дүн | 0 | 66.71 | 67.05 | 67.33 | 67.62 |
| | Дундговь | 348 | 71.48 | 71.54 | 71.26 | 71.27 |
| Эмэгтэй | Улсын дүн | 0 | 76.22 | 76.47 | 76.7 | 76.85 |
| | Дундговь | 348 | 79.38 | 79.51 | 79.84 | 80.03 |

"Дундговь-боловсролын чанар" төсөл хэрэгжүүлж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр захирамжаар "Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жил" болгон зарлан "Дундговь-боловсролын чанар" төслийг аймгийн ИТХ-ын 2022 оны 61 дүгээр тогтоолоор 300,0 сая төгрөгийн санхүүжилт баталж, хэрэгжүүлэн төслийн хэрэгжилт 88,7 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдэв.

Аймгийн хэмжээний нийт 19 сургуулиас Сайхан-Овоо сумын сургууль, Сайнцагаан сумын Говийн ирээдүй, Хүмүүнлэг сургуулийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулсан байна.




ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2024 оны 2 зорилтын хэрэгжилтийг хянан үнэлээд өөрийн үнэлгээгээр 88,9% буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэлээ.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг стратеги төлөвлөгөөтэй нийцэж байгаа эсэхэд шинжилгээ хийж, харьцуулан дараа жилийн төлөвлөлтөд зөвлөмж өгч ажиллаж байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 36 зорилт, 120 арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн дагуу суурь түвшин, зорилтот түвшин, хүрсэн түвшнийг харьцуулан хяналт шинжилгээ, үнэлгээг хийхэд Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн хүрээний төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт бусад нэгжээс доогуур хэрэгжиж байна.


| № | Агуулга | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо | Арга хэмжээний биелэлт |
|---|--|--------------|--------------------|------------------------|
| Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийн зорилтын хүрээнд | | | | |
| 1 | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс | 2 | 9 | 66,6% |
| 2 | Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс | 5 | 16 | 95% |
| 3 | Санхүү төрийн сангийн хэлтэс | 2 | 10 | 87% |
| 4 | Цэргийн штаб | 1 | 2 | 100% |
| 5 | Залуучууд хөгжлийн төв | 1 | 3 | 100% |
| Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд | | | | |
| 1 | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс | 3 | 14 | 86,2% |
| 2 | Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс | 6 | 18 | 88,0% |
| 3 | Санхүү төрийн сангийн хэлтэс | 1 | 2 | 100% |
| 4 | Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс | 1 | 5 | 100% |
| 5 | Хууль, эрх зүйн хэлтэс | 6 | 16 | 88,7% |
| 6 | Нийгмийн бодлогын хэлтэс | 5 | 19 | 86% |
| 7 | Цэргийн штаб | 1 | 2 | 100% |
| 8 | Залуучууд хөгжлийн төв | 1 | 4 | 96,2% |

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлтийн шатанд хяналт шинжилгээ хийж, зөвлөмж өгч ажилласнаар төлөвлөлт, гүйцэтгэлийн чанар дээшилж байна.



Байгууллагын нэгжүүдийн хариуцан хэрэгжүүлсэн арга хэмжээний үнэлгээг харьцуулж үзэхэд Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт бусад нэгжээс доогуур, үзүүлэлттэй байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2 үндсэн чиглэлийн хүрээнд хэрэгжилтийг өмнөх онуудтай харьцуулалт хийж үзэхэд 2024 онд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт буурсан үзүүлэлттэй байна.



Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийн зорилтын хүрээнд чанарын удирдлагын тогтолцооны тогтвортой байдал хангагдаагүй, мөн дээд сургуулийн салбар сургууль байгуулах ажил хэрэгжээгүй байна.

Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд цахим аймаг хөтөлбөр боловсруулж Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулах, дулааны станцын 2 дугаар хэлхээний дэд бүтцийн ажлын хэрэгжилт, төрийн архивт орон тоо нэмэгдүүлэх, угийн бичиг хөгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтүүд удаашралтай, хэрэгжилт хангалтгүй байгаагийн шалтгааныг тодруулахад 50 хувь нь зохион байгуулалтаас, үлдсэн хэсэг нь төсөв хөрөнгөөс шалтгаалж хэрэгжээгүй байна.

Төсөв санхүүгийн шинжилгээ

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 2024 онд нийт 22 тэрбум 287,1 сая төгрөг зарцуулсан байна. Үүнээс: Улсын төсвийн хөрөнгөөр 1 тэрбум 109,6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 4 тэрбум, 909,4 сая төгрөг, хандив тусламжаар 308,1 сая төгрөг, гадаадын зээл тусламж болон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар 18 тэрбум 960 сая төгрөг зарцуулж хэрэгжүүлсэн байна.



Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээг тооцож, эхний хагас жил, жилийн эцсийн төсөв зарцуулалтад анализ хийж үзэхэд эхний хагас жилд 3 тэрбум, 965 сая төгрөг, сүүлийн хагас жилд 21 тэрбум, 322,1 сая төгрөг зарцуулж, нийт зарцуулсан хөрөнгийн 16 хувийг эхний хагас жилд зарцуулсан байна.

Зарцуулсан хөрөнгийн 83 хувийг төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байгаа нь өнгөрсөн оноос 2 хувиар илүү байна.

Зарцуулсан хөрөнгийн хэмжээг зорилтын хүрээгээр харьцуулж гаргалаа.

| № | Эх үүсвэр | Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийн зорилтын хүрээнд | Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд | Дүн |
|---|---|--|---|---------|
| 1 | Улсын төсвийн хөрөнгө оруулалт | 232,6 | 877,0 | 1109,6 |
| | Орон нутгийн төсөв | 2185,5 | 2723,9 | 4909,4 |
| | Хувийн хэвшил, хандив | 308,1 | | 308,1 |
| | Гадаадын хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр | 1500,0 | 17460,0 | 18960,0 |
| | Нэгтгэл | 4226,2 | 21060,9 | 25287,1 |

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 2024 онд өмнөх оноос 13 хувиар илүү төсөв зарцуулсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалт өмнөх онуудад өндөр зарцуулалттай байгаа нь өмнөх жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа харьяа доод шатны газар, хэлтэс, агентлагийн ажлыг давхар төлөвлөсөн байдалтай холбоотой байна.

| Агуулга | Улсын төсөв | Орон нутгийн төсөв | Хандив тусламж | Төсөл хөтөлбөр | Нийт дүн |
|---------|-------------|--------------------|----------------|----------------|----------|
| 2022 он | 33937,3 | 10388,9 | 1992,4 | 8884,0 | 55202,6 |
| 2023 он | 15992.0 | 5557.9 | 516.0 | 242.5 | 22307.5 |
| 2024 он | 1109,6 | 4909,4 | 308,1 | 18960,0 | 25287,1 |

Зарцуулсан хөрөнгийн хэмжээг үйл ажиллагааны чиглэлээр задалж үзэхэд Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд бүтээн байгуулалт ба дулааны цахилгаан станцын барилгын ажлыг гадаадын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа нь зарцуулсан хөрөнгийн 72 хувийг эзэлж байна. Нийт зарцуулсан төсвийн 19,4 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө эзэлж байна.

Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх явцад төлөвлөлтийн зорилт арга хэмжээг стратеги төлөвлөгөөтэй уялдуулаагүй, шалгуур үзүүлэлтийг оновчгүй төлөвлөсөн, хэрэгжилтэд зарцуулсан төсөв, эх үүсвэр тодорхойгүй, гарсан үр дүн тодорхойгүй, тоон мэдээллийг буруу тайлагнах байдал түгээмэл байгаа нь харьцуулалт, нэгтгэл хийх ажилд хүндрэл үүсгэж байгаад хэрэгжилтийг нэгтгэж, үнэлгээ хийлгэж байгаа Төрийн захиргааны хэлтсээс цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүдэд:

1. Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу, зорилтот түвшинд хүрсэн эсэхийг ойлгомжтой байдлаар, тоо баримттайгаар үр дүнд хүрсэн эсэхийг тодорхой, баримтжуулан, хянаж тайлагнах
2. Зарцуулсан төсвийн хэрэгжилтийг тайлагнахдаа сая.төгрөгөөр, тоо баримтыг эмх цэгцтэй, эх үүсвэрийг тодорхой, тус туст нь ялгаж тооцож тайлагнах
3. Цаашид төлөвлөлтийг хийхдээ зорилт, арга хэмжээ 2-ын уялдааг сайн хангах, стратеги төлөвлөгөөтэй уялдуулан шалгуур үзүүлэлтийг бодитой зөв томьёолох шаардлагатай байгааг онцолж байна.

БАТАЛГААЖУУЛСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

ТАЙЛАН БИЧСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН



Б. ЛХАГВАБААТАР

Д. ДААРИЙМАА

Н. ДЭЛГЭРМАА